

**"ДОРНОД ХУДАЛДАА" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 05 дугаар сарын 15

№01

Чойбалсан хот

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫГ
ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59, 60, 61, 65, 67 дугаар зүйл, санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12-р сарын 14-ны өдрийн 377 дугаар тоот "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай" журмыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. "Дорнод худалдаа" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн Лхагва гарагийн 10:00 цагт Дорнод аймаг, Хэрлэн сум, 6-р баг "Дорнод худалдаа" ХК-ийн байранд зарлан ХУРАЛДУУЛСУГАЙ.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр ОРУУЛСУГАЙ.

- ✓ Төлөөлөн удирдах зөвлөл сонгох
- ✓ Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан түүнд хийгдсэн аудитын дүгнэлтийг ТУЗ-өөр хэлэлцэх
- ✓ Компанийн 2026, 2027 оны бизнес төлөвлөгөөг, чиглэлийг хэлэлцэх, батлах тухай
- ✓ Ноогдол ашиг хуваарилах эсэх тухай
- ✓ Бусад

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах, бүртгэлийн өдрийг 2025 оны 06 дугаар сарын 04-ны өдрөөр ТОГТООСУГАЙ.

4. Компанийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчидэд хурлын зарыг хүргэхээр 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдөр тутмын 02- оос доошгүй сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээллэх, энэ мэдээллийг дээрх хэлбэр шаардлагын дагуу анх мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 06 дугаар сарын 04-нд дахин мэдээллэхийг ТУЗ-ийн Нарийн бичгийн даргад ДААЛГАСУГАЙ.

5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан баримт бичгийн жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар, хурлын зарыг 2 дугаар хавсралтаар, хурлын дэгийг 3 дугаар хавсралтаар, хуралтай холбоотой танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг 4 дүгээр хавсралтаар, хуралд санал авах саналын хуудасны загварыг 5 дугаар хавсралтаар тус тус БАТЛАСУГАЙ.

6. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд энэхүү шийдвэрийн 02 дугаар хавсралтанд заасан бичиг баримттай 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс хойш ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд компанийн байранд Хурал зохион байгуулах комиссоос авч танилцах эрхтэй болохыг ДУРЬДСУГАЙ.

7. Хувьцаа эзэмшигчдээс "Санал авах хуудас"-ыг хүлээн авах сүүлчийн өдрийг 2025 оны 06 дугаар сарын 19- ны 15:00 цагаар ТОГТООСУГАЙ.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг удирдах:

Хурлын даргаар: Д.Тунгалагтуул

Тооллогын комиссын даргаар: Ш.Билгүүн

Тооллогын комиссын гишүүдэд: Д.Эрдэнэболд,

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын албан үүргийг
Б.Батцэцэг нарыг тус тус ТОМИЛСУГАЙ.

10. Компаний төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын дэд хороог 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан даргаар нь Ш.Билгүүн, Д.Эрдэнэболд, Ш.Нямдулам нарыг байхаар ТОМИЛСУГАЙ.

11. Хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Санхүүгийн Зохицуулах Хороо, "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-д хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комиссын дарга (Д.Шинэбаяр)-д даалгасугай.

12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссын баталсан төсвийн хүрээнд холбогдох зардлыг үйл ажиллагааны зардлаас зарцуулахыг (Д.Шинэбаяр)-д зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Д.ТУНГАЛАГТУУЛ

